

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Халамжийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/30/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Г.Шүрэнцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт.....	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.25 № 1-6/1111

танай _____-ны № _____-г

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ХАЛАМЖИЙН САНГИЙН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

442509057

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	-	-
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	-	-
	АВЛАГА [7]+[10]	-	-
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	-	-
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	-	-
41	Богино хугацаат өр төлбөр [18]+[21]+[22]+[23]	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [16]+[24]	-	-
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	-	-
510301	Өмнөх үеийн үр дүн	-	-
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	-	-
510302	Тайлант үеийн үр дүн	-	-
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	-	-
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	-	-
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	94,600,000.00	90,183,500.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого	94,600,000.00	90,183,500.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	94,600,000.00	90,183,500.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	94,600,000.00	90,183,500.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	45,600,000.00	42,000,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	49,000,000.00	48,183,500.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	94,600,000.00	90,183,500.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	94,600,000.00	90,183,500.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого	94,600,000.00	90,183,500.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	94,600,000.00	90,183,500.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[38]	94,600,000.00	90,183,500.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	45,600,000.00	42,000,000.00
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	49,000,000.00	48,183,500.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64]	94,600,000.00	90,183,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН КАПИТАЛ	ХУРИМТЛАДСАН ҮР ДҮН	ЗГ-ЫН ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-
2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-
2024 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

САНГИЙН ОРЛОГО	ТӨЛӨВЛӨГӨӨ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]	146,400,000.00	90,183,500.00	56,216,500.00	61.60
Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт	97,200,000.00	42,000,000.00	55,200,000.00	43.21
Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	49,200,000.00	48,183,500.00	1,016,500.00	97.93
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	146,400,000.00	90,183,500.00	56,216,500.00	61.60

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй.

3.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

3.3 Зөвлөмж

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.